

БАТЛАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА  Д.СОДНОМ



## ОТОГ ҮҮСГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

### 1.Ерөнхий зүйл

1. Боржигины 17 сумдын өвлөн уламжлагчид “Боржигин-2019” наадмын хүрээнд зохион байгуулагдах Боржигины өв соёл, ёс уламжлалыг сурталчилсан наадмын зохион байгуулах хорооноос заасан талбайд тус бүр отгоо байрлуулна.
2. Отгийн хаягыг наадам зохион байгуулах хорооноос нэгдсэн байдлаар хийнэ.
3. Отог байгуулж, орчин бүрдүүлэхэд дараах зүйлсийн бэлтгэн ирнэ. Үүнд:
  - 3.1 Сумдууд төв талбайд хүндэтгэлийн гэр барина. Үүнд: тав ба түүнээс дээш ханатай улаан халзтай цагаан бүрээстэй гэр барьж оролцоно. Хүндэтгэлийн гэрийг дагалдаж аж ахуйн гэр ард талд нь баригдана.
  - 3.2 “Боржигины өв соёл”-ыг сурталчилсан 5 аймгийн 17 сумын гэр байрлана. Сум бүр отгийн нэг гэртэй ирнэ. Гэрүүд отгийн зарчмаар байрлаж, боржигины соёлын 5 ай савын төрөл зүйлийг харуулсан үндэсний ахуйн орчныг бүрдүүлж, зан үйл, ёслол, үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд үзүүлнэ.
  - 3.3 Орон нутгийн бэлэгдэл, туг далбааг авчирна. Оролцогчид үндэсний хувцастай жагсаалд оролцно.
  - 3.4 Байгалийн үзэгдэл бороо, салхинаас хамгаалах дулаалга, бэхлэгээг бэлтгэсэн байна.
  - 3.5 Отгийн гадна талбайд тухайн нутаг үндэсний ахуйг харуулсан орчин бүрдүүлсэн байна.
  - 3.6 Сум орон нутгийг сурталчилах, соёлын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, гар урлалын бүтээгдэхүүн худалдааг наадам зохион байгуулах хорооноос заасан цэгт худалдаалж болно.

### 2.Анхааруулга

- 2.1 Үнэтэй, ховор эд зүйлсийн хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг тухайн сум хариуцна.
- 2.2 Отгийн үзүүлэлтэнд ашиглах гар, урлалын эд зүйлсийг наадмын шүүгчдийн дүн гартал зарж борлуулж болохгүй.

### 3. Отгийн ажиллах цагийн хуваарь, баримтлах зарчим, дэг журам

- 3.1 “Боржигин-2019” их наадмын отгийн үйл ажиллагааны цагийн хуваарь:
  - ❖ 09:00-10:00 цагт Отгийг нээж ажиллуулах бэлтгэл ажлыг хангах
  - ❖ 10:00-16:00 цагт Отгийн үндсэн үйл ажиллагаа
  - ❖ 2019 оны 07 дугаар сарын 26-ний өдөр наадам зохион байгуулагдах газар ирж байрласан байна.

❖ 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдөр сумдууд отгоо буулгаж, орон нутагруу буцна.

3.2 “Боржигин-2019” их наадмын үргэлжлэх хугацаанд оролцогчид хөтөлбөрийн дагуу цагийг чанд баримтлаж үйл ажиллагаанд оролцно.

3.3 Наадамд оролцогчид хүмүүнлэг аж төрх ёсыг баримтлан, цэвэр цэмцгэр, байгальд хог хаяхгүй, нийгмийн хэв журмыг сахиж, архи согтууруулах ундааг хэрэглэхгүй байх.

3.4 Отог болон үйл ажиллагаа явагдаж байгаа газар, талбайг орхиж явахыг хориглоно.

#### **4. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАНГАХ ЗААВАРЧИЛГАА**

##### **1. Аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага:**

Наадам зохион байгуулах хорооноос гаргасан “отог үүсгэх үйл ажиллагааны заавар” болон бусад зааварчилгааг мөрдөнө.

1.1 Наадмын талбайд баримтлах нийгмийн хэв журам сахиулах, тогтоосон дүрэм журмыг мөрдөнө.

1.2 Гэмтэл осол, хулгай, галын аюулаас урьдчилан сэргийлэх

1.3 Отог, майханыг эзэнгүй орхих, хараа хяналтгүй байлгах аас болон эд зүйлээ ил задгай орхихоос сэргийлнэ.

1.4 Зөвхөн зөршөөрөгдсөн газарт тамхи татна.

##### **2. Эрүүл ахуйн зааварчилгаа**

2.1 Эрүүл мэндээ хамгаалах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх

2.2 Наадмын талбай, отог дээр эмх цэгцтэй, ахуйн болон ариун цэврийн шаардлагыг хангах

2.3 Оролцогчдын эрүүл мэндийн байдал эвгүйрхэх, өвдөх тохиололд эмнэлэгийн үйлчилгээний цэгт хандаж эмнэлэгийн тусламж үйлчилгээ авна

2.4 Ариун цэврийн шаардлагад хангасан зориулалтын газар хоол хүнсээ боловсруулж иднэ. Хоолны ходлого наршихаас сэргийлэх

##### **3. Хориглох зүйлс :**

3.1 Согтууруулах төрлийн ундаа хэрэглэх

3.2 Ил гал гаргах, тамхи татах

3.3 Ил задгай бие засах, нус цэрээ хаях

3.4 Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, бусдын биед

халдах

3.5 Цахилгаан тоног төхөөрөмжийг дураар салгах, залгах

3.6 Уламжлалт ёс заншлаа даган байгальд ээлтэй соёлыг түгээж, хог хаягдалыг ил задгай хаяхыг хориглоно.

**“БОРЖИГИН 2019”**  
**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМД СУМДААС**  
**ОРОЛЦОГЧДЫН МЭДҮҮЛЭГ**

Сумдын нэр:..... 2019 оны.... сарын ....өдөр

№	Оролцож буй сум	Овог, нэр	Оролцсон төрөл	Төрсөн огноо	Хүйс	Албан тушаал	Гавьяа шагнал	Холбоо барих утас, мэйл хаяг
Сумдаас төлөөлөгчөө зохион байгуулж, хариуцах ахлагч								
1								
2								
Жич: хэдэн хүний бүрэлдэхүүнтэй оролцох, тоглолтын сценарийг бичнэ.								
I.		II. Эх хэл, түүгээр илэрхийлэгдэх аман уламжлал, бусад илэрхийллүүд						
1	Баянтал сум	Д.Сам данба зар	Цол дуудах	1966 он	Эр	Жижүүр	МУ-ын тэргүүний ардын авьяастан	95591367 Гэх мэтээр төрөл тус бүр дээр оролцох хүмүүсийн мэдээллийг бичин ирүүлнэ.
III.	IV. Язгуур урлаг тоглон үзүүлэх илэрхийллүүд							
V.	VI. Зан үйл, ёс заншил, ёслол баяр наадмууд							
VII.	VIII. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, арга ухаан							
IX.	X. Уламжлалт гар урлал							

Мэдүүлэг гаргасан: овог нэр, албан тушаал

Хянаж батласан: дарга овог нэр, албан тушаал

Жич: Тоглолтын хөтөлбөр дараалал, оролцогчдын анкетыг [govisumber@mecs.gov.mn](mailto:govisumber@mecs.gov.mn) хаягаар 2019 оны 07 сарын 18-ний өдөр ирүүлэх.

Холбоо барих утас: 990793355, 99143342, 99014021, 99148717 дэлгэрэнгүй мэдээлэл авах